



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/207

Улаанбаатар хот

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын  
тархалтын үе шат, түвшинг үнэлэх түр  
заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.5, 8.1.13 дахь заалт, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шат, түвшинг үнэлэх түр зааврыг хавсралтаар баталсугай.
2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шат, түвшинг үнэлж, хариу арга хэмжээний чиглэл гаргаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.
3. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил аргагүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/-т үүрэг болгосугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141221035



Эрүүл мэндийн сайдын ..... оны  
04 сарын 07-ны өдрийн 427 дугаар  
тушаалын хавсралт

## **КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАРХАЛТЫН ҮЕ ШАТ, ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ТҮР ЗААВАР**

### **Нэг. Үндэслэл**

1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шат, түвшинг үнэлэх энэхүү түр заавар нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хэрэгжүүлэх гол чиглэл болно.

1.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шатыг халдварт өвчний тандалтын болон олон эх сурвалжит салбар хоорондын мэдээнд үндэслэн тогтоож, сум, аймаг, нийслэл, улсын хэмжээнд тохирсон хариу арга хэмжээг зохион байгуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын статистик болон тандалтын тоон мэдээнд дүн шинжилгээ хийж, долоо хоногийн өөрчлөлтийг шалгуур үзүүлэлттэй харьцуулан дүгнэлт хийж, халдварын үе шат, түвшинд тохирсон нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шат, түвшингийн үнэлгээ хийх түр зааврыг боловсруулахдаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг тохируулан хэрэгжүүлэх” түр удирдамжийг үндэслэл болгов.

### **Хоёр. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шат, түвшин**

2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шат, түвшинг дараах байдлаар ангилна. Үүнд:

- 2.1.1. Ногоон түвшин - Тархалт бага, тогтвортой - (I)
- 2.1.2. Шар түвшин - Зөөвөрлөгдсөн/алаг цоог тархалттай - (II)
- 2.1.3. Улбар шар түвшин - Халдвар голомтот тархалттай - (III)
- 2.1.4. Улаан түвшин - Халдвар хүн амын дунд тархсан - (IV)

### **Гурав. Тархалтын үе шат, түвшинг үнэлэх байгууллага, давтамж**

3.1. Тархвар судлалын долоо хоногоор тасалбар болгон (7 хоног бүрийн Баасан гарагаас дараа 7 хоногийн Бямба гараг хүртэл) коронавируст халдвар (КОВИД-19)-ын тоон мэдээнд дүн шинжилгээ хийж, халдвар тархалтын үе шатны үнэлгээг хийнэ.

3.2. Шаардлагатай тохиолдолд коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шатны үнэлгээг шаардлагатай үед хугацаа харгалзахгүй хийж болно.

3.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын халдвар тархалтын үе шат, түвшинг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын оролцоог ханган хийнэ. Үүнд:



3.3.1. Монгол Улсын хэмжээний үнэлгээг Халдварт өвчин судлалын үндэсний төв;

3.3.2. Нийслэлийн хэмжээний үнэлгээг Халдварт өвчин судлалын үндэсний төв, Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран хийнэ;

3.3.3. Аймгийн хэмжээний үнэлгээг аймгийн Эрүүл мэндийн газар, Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран хийнэ;

3.3.4. Сумын түвшний үнэлгээг аймгийн Эрүүл мэндийн газар, сумын эрүүл мэндийн төвтэй хамтран хийнэ.

3.4. Халдварт өвчин судлалын үндэсний төв нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шат, түвшингийн улсын хэмжээний үнэлгээний дүн, дүгнэлт, саналыг нэгтгэн Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газарт “Монгол улс дахь коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын долоо хоногийн тойм” мэдээнд нэг бүлэг болгон оруулж мэдээлнэ.

3.5.ЭМЯ-наас “Монгол Улс дахь коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын тойм мэдээ”, хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт долоо хоног бүр Улсын онцгой комисс, Нэгдсэн шуурхай штабт мэдээлнэ.

#### **Дөрөв. Халдварын тархалтын үе шат, түвшинг үнэлэх тоон мэдээ цуглуулах**

4.1. Тухайн тархвар судлалын долоо хоногийн тархалтын үе шат, түвшинг үнэлэхэд шаардлагатай тандалтын тоон мэдээг дараах эх сурвалжаас цуглуулна. Үүнд:

4.1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын тоон мэдээг [tandalt.mn](http://tandalt.mn) онлайн програм хангамжид бүртгэгдсэн мэдээний сан, Монгол Улс дахь коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын долоо хоногийн тойм мэдээ;

4.1.2. Лабораторийн шинжилгээний эерэг илрэлтийн хувийг [tandalt.mn](http://tandalt.mn) онлайн програм хангамжид бүртгэгдсэн мэдээний сан, Монгол Улс дахь коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын долоо хоногийн тойм мэдээ;

4.1.3. Амбулаторийн үзлэгт томуу, томуу төст өвчний эзлэх хувийг [flu.mn](http://flu.mn) онлайн програм хангамжид бүртгэгдсэн мэдээний сан;

4.1.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хэвтэн эмчлүүлэгчдийн тоон мэдээг [burtgel.mohs.mn](http://burtgel.mohs.mn) онлайн програм хангамжид бүртгэгдсэн мэдээний сан;

4.1.5. Шинээр оношлогдсон тохиолдлын дундах дотоодын халдварын эзлэх хувийг Монгол Улс дахь коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын долоо хоногийн тойм мэдээ;

4.1.6. Эрүүл мэндийн ажилтны дундах халдварыг [tandalt.mn](http://tandalt.mn) онлайн програм хангамжид бүртгэгдсэн мэдээний сан, Монгол Улс дахь коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын долоо хоногийн тойм мэдээ;

4.1.7. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эзлэх хувийг Монгол Улс дахь коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын долоо хоногийн тойм мэдээ;

4.1.8. Эрүүл мэндийн ажилтны эмнэлгийн бус орчинд халдвар авсан хувийг Монгол Улс дахь коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын долоо хоногийн тойм мэдээ;



4.1.9. Эх уурхай тодорхойгүй кластерийн эзлэх хувийг tandalt.mn програм хангамжид бүртгэгдсэн мэдээний сан, Монгол Улс дахь коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын долоо хоногийн тойм мэдээ;

4.1.10. Уушгины хатгалгаа өвчний улмаас эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж буй өвчтний тоог flu.mn онлайн програм хангамжид бүртгэгдсэн мэдээний сан;

4.1.11. Бүх шалтгааны улмаас эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж буй өвчтний тоог burtgel.mohs.mn онлайн програм хангамжид бүртгэгдсэн мэдээний сан;

4.1.12. Бүх шалтгаант нас баралтын тоог статистикийн H-info онлайн програм хангамжид бүртгэгдсэн мэдээний сан;

4.1.13. Уушгины хатгалгаагаар нас барсан өвчтний тоог H-info болон flu.mn онлайн програм хангамжид бүртгэгдсэн мэдээний сан;

4.1.14. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын улмаас нас барсан хүний тоон мэдээг статистикийн H-info онлайн програм хангамжид бүртгэгдсэн мэдээний сан, Монгол Улс дахь коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын долоо хоногийн тойм мэдээ;

4.1.15. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үхлийн түвшинг Монгол Улс дахь коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын долоо хоногийн тойм мэдээ;

4.1.16. Амьсгалын аппаратын тоог burtgel.mn програм хангамжид бүртгэгдсэн мэдээний сан.

#### **Тав. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шат, түвшинг үнэлэх**

5.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шат, түвшинг дараах 3 үндсэн шалгуур болон харгалзах үзүүлэлтийн дагуу үнэлнэ. Үүнд:

5.1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үндсэн үзүүлэлтийг тооцох;

5.1.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эх уурхайг тогтоох;

5.1.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хүндрэлийг үнэлэх.

5.2. Халдварт өвчин судлалын үндэсний төв нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шат, түвшинг үнэлэх нарийвчилсан заавар, аргачлалаар эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийг хангана.

5.3. Коронавируст халдвар (КОВИД-19) тархалтын үе шат, түвшинг үнэлэх тандалтын тоон мэдээг сум, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагууд долоо хоногоор нэгтгэнэ.

5.4. Засгийн газрын 2022 оны 1 дүгээр тогтоолын дагуу коронавируст халдвар (КОВИД-19) тархалтын үе шат, түвшинг Нийслэл, аймаг, сумын түвшинд үнэлэхдээ дараах босго үзүүлэлтийг ашиглана (Хүснэгт 1).



Хүснэгт 1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шат, түвшинг үнэлэх босго үзүүлэлт

Тархалтын үе шат	Улсын түвшинд					
	Нийслэлийн түвшинд		Аймгийн түвшинд		Сумын түвшинд	
	Шинэ тохиолдлын түвшин, (100,000 хүн амд)	бх-ПГУ шинжилгээний эерэг хувь	Шинэ тохиолдлын түвшин, (10,000 хүн амд)	бх-ПГУ шинжилгээний эерэг хувь	Шинэ тохиолдлын түвшин, (1,000 хүн амд)	бх-ПГУ шинжилгээний эерэг хувь
Тархалт бага, тогтвортой	10-99.9	0 - 6.9%	1-9.9	0 - 4.9%	1-4.99	0 - 1.9%
Зөөвөрлөгдсөн/алаг цоог тархалттай	100-199.9	7 - 9.9%	10-19.9	5 - 7.99%	5-9.9	2 - 4.9%
Голомтот тархалттай	200-499.9	10 - 14.9%	20-49.9	9 - 9.99%	>10-14.9	5 - 7.9%
Хүн амын дунд тархсан	500-аас дээш	> = 15%	50-99.9	> = 10%	>=15	>= 8%

5.5. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тухайн 7 хоногийн тандалтын тоон мэдээнд дүн шинжилгээ хийж, “босго үзүүлэлт”-тэй харьцуулан улс, нийслэл, аймаг, сумын хэмжээнд коронавируст халдвар (КОВИД-19) тархалтын үе шат, түвшинг тогтооно.

5.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалтын тоон мэдээний дүн шинжилгээ хийхдээ дараах шалгуурыг баримтлана (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үе шатыг үнэлэх шалгуур, түвшин

Үндсэн шалгуур	Харгалзах үзүүлэлт	Тодорхойлолт, тооцоолол	Үе шат, түвшинг үнэлэх шатлал
Үндсэн үзүүлэлтийг тооцох	Шинээр батлагдсан тохиолдлын тоо	Тухайн долоо хоногт шинээр батлагдсан нийт коронавируст халдвар (КОВИД-19)-тай өвчтний тоо	- Улс - Нийслэл - Аймаг - Сум
	бх-ПГУ шинжилгээний эерэг илэрсэн хувь	бх-ПГУ шинжилгээний эерэг тохиолдлын тоог нийт цуглуулсан сорьцын тоонд харьцуулна.	- Улс - Нийслэл - Аймаг
	Амбулаториор үйлчлүүлэгчдийн дундах амьсгалын замын өвчний эзлэх хувь	Тухайн долоо хоногт амбулаториор үйлчлүүлэгчдийн дундах томуу, томуу төст өвчтэй үйлчлүүлэгчийн эзлэх хувь	- Улс - Нийслэл - Аймаг
	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын хэвтэн	Тухайн долоо хоногт коронавируст халдвар (КОВИД-19)-ын улмаас хэвтэн эмчлүүлж буй өвчтний тоо	- Улс - Нийслэл - Аймаг - Сум



	эмчлүүлэгчдийн тоон мэдээ		
Эх уурхайг тогтоох	Шинээр оношлогдсон тохиолдлын дундах дотоодын халдварын эзлэх хувь	Дотоодын шинэ халдварын тоог шинээр зөөвөрлөгдөж ирсэн халдварын тоонд хуваана.	- Улс - Нийслэл - Аймаг
	Эрүүл мэндийн ажилтнуудын дундах халдвар	Тухайн долоо хоногт бүртгэгдсэн шинээр халдвар авсан эрүүл мэндийн ажилтнуудын тохиолдлын тоо	- Улс - Нийслэл - Аймаг
	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эзлэх хувь	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар авсан эрүүл мэндийн ажилтны тохиолдлын тоог нийт эрүүл мэндийн ажилтнуудын тохиолдлын тоонд хуваана.	- Улс - Нийслэл - Аймаг
	Эрүүл мэндийн ажилтнууд эмнэлгийн бус орчинд халдвар авсан эзлэх хувь	Эмнэлгийн бус орчинд халдвар авсан эрүүл мэндийн ажилтны тоог нийт эрүүл мэндийн ажилтнуудын тохиолдлын тоонд хуваана.	- Улс - Нийслэл - Аймаг
	Эх уурхай тодорхойгүй кластерийн эзлэх хувь	Тухайн орон нутагт бүртгэгдсэн эх уурхай тодорхойгүй кластерийн тоог нийт кластерийн тоонд харьцуулна.	- Улс - Нийслэл - Аймаг - Сум
Хүндрэлийг үнэлэх	Уушгины хатгалгааны улмаас эрчимт эмчилгээний тасагт хэвтэж буй өвчтөний тоо	Тухайн долоо хоногт уушгины хатгалгаа оноштойгоор эмнэлэгт шинээр хэвтсэн өвчтний тоо	- Улс - Нийслэл - Аймаг - Сум
	Бүх шалтгааны улмаас эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлэгдэж буй өвчтний тоо	Тухайн долоо хоногт бусад шалтгааны улмаас эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж буй хүмүүсийн тоо	- Улс - Нийслэл - Аймаг - Сум
	Нийт нас баралтын тоо	Тухайн долоо хоногт бүртгэгдсэн бүх шалтгаант нас баралтын тоо	- Улс - Нийслэл - Аймаг
	Уушигны хатгалгаагаар нас барсан өвчтний тоо	Тухайн долоо хоногт уушигны хатгалгаагаар нас барсан нийт тохиолдлын тоо	- Улс - Нийслэл - Аймаг - Сум
	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын улмаас нас барсан өвчтний тоо	Тухайн долоо хоногт коронавируст халдвар (КОВИД-19)-ын улмаас нас барсан тоо	- Улс - Нийслэл - Аймаг - Сум

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үхлийн түвшин	Нийт коронавируст (КОВИД-19)-ын баралтын бүртгэгдсэн халдвар (КОВИД-19) батлагдсан тохиолдлын хуваана.	бүртгэгдсэн халдвар нас шалтгаант нас тоог нийт коронавируст (КОВИД-19) халдвар (КОВИД-19) батлагдсан тохиолдлын тоонд	<ul style="list-style-type: none"> <li>- Улс</li> <li>- Нийслэл</li> <li>- Аймаг</li> <li>- Сум</li> </ul>
Амьсгалын аппаратын тоо	Тухайн долоо хоногт ашиглаагүй амьсгалын аппаратны тоо		<ul style="list-style-type: none"> <li>- Улс</li> <li>- Нийслэл</li> <li>- Аймаг</li> <li>- Сум</li> </ul>